



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/979

Мандалговь

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай 01 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтад орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэхээр батлагдсан "Сайнцагаан сумын 6 дугаар цэцэрлэгийн барилгын засвар"-ын ажлын гүйцэтгэгчээр "Чонон сүлд констракшн" ХХК шалгарсан тул 188,357,915 (нэг зуун наян найман сая гурван зуун тавин долоо мянга есөн зуун арван тав) төгрөгөөр тус ажлын гэрээг байгуулсугай.

2. Батлагдсан төсвийн дагуу засварын ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "Чонон сүлд констракшн" ХХК (Б.Сэр-Од)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай байгуулсан гэрээнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100721